



## АНГЛИ ХЭЛНИЙ БИЧИХ ДАДЛЫН ХИЧЭЭЛ ЗААХ АРГЫН ЗАРИМ АСУУДАЛ

У.Лхагвасүрэн  
МУИС-ийн ХС-ийн ГХСТ-ийн багш

**Abstract:** Writing has been a neglected area of English language teaching for some years. It is relatively recent that ideas generated from the research, initially into first language writing and later into second language writing have begun to influence on the development of writing and its methodology. The role of writing in English in everyday life has changed quite dramatically over recent two decades. Many students have specific needs that require them to work on their writing skills: academic study, examination preparation, business English etc. In order to help students develop their writing skills teachers should identify the most appropriate teaching methods.

**Түлхүүр үг:** академик бичвэр, даалгавар, бичих, эссэ

Сүүлийн хэдэн жилд англи хэлний хичээлд англиар бичих дадал нэлээн гээгдээд байсан билээ. Унших болон хэлзүйн холбогдолтой сурах бичиг их байдаг боловч англиар хэрхэн бичих талаарх сурах бичиг ховор байдаг нь үүнийг харуулж байна.

Англи хэлний бичих дадал хичээлээр англи хэлний суурь мэдлэгт тулгуурлан төрөл бүрийн бичвэрийг их сургууль коллежийн түвшинд англи хэл дээр бичүүлж сургахад болон тодорхой сэдвийн хүрээнд өөрийн санал бодлоо бичгээр илэрхийлэх чадварыг эзэмшүүлэхэд оршино. Англи хэлээр ярьдаггүй улс орны хүмүүсийн дунд гардаг хэлний авиа зүй, хэлзүй, үгийн сан, өгүүлбэрзүй гэх мэт бүх түвшний алдааг залруулах дасгал хийхээс гадна дүрслэн бичих, тайлбарлан бичих, жишээ бичих,

ангиалан бичих, харьцуулан бичих, шалтгаан ба үр дагавар гэсэн сэдвүүд дээр ажилладаг. Түүнчлэн ерөнхийлөх ба нарийвчлан бичих, тоон үзүүлэлт буюу график тайлбарлаж сурах нь оюутнуудын англи хэлний бусад хичээлд төдийгүй дараагийн шатны сургалтад зайлшгүй хэрэгтэй юм.

Багш оюутнуудаа ямар ч төрлийн бичвэрийг зөв, зохион байгуулалт сайтай бичдэг болгохын тулд олон аргыг туршиж үздэг нь дамжиггүй. Дараах 10 таамаглалыг англи хэлний бичих дадал хичээл заахад ихээхэн үүрэг гүйцэтгэж болох юм гэж үзээд дэвшүүлж байна.

### 1. Англиар бичих шалтгаан

- Оюутнуудад англи хэлний бүтцийг заахын тулд
  - Оюутнуудад гарч буй дэвшил, чадварыг дүгнэхийн тулд
  - Оюутнуудын сурах зорилго, хэрэгцээг хангахын тулд
  - Хичээл дээр дуугарахаас эмээдэг оюутнуудад хэлний ур чадвараа харуулах боломж олгохын тулд
  - Оюутан өөрийгөө илэрхийлэх аргыг хөгжүүлэхийн тулд
  - Оюутанд чимээгүй сууж хийх дасгал болгож
  - Оюутан хэлийг илүү ухамсарт байдлаар судалж, эргэцүүлэн бодох арга хэрэгсэл болгож
  - Оюутны оюуны чадварыг хөгжүүлэх, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх зорилгоор.

Ихэвчлэн жагсаалтын эхэнд байгаа шалтгаанаар англи хэл дээр бичих дасгал өгдөг билээ. Жишээлбэл: шинэ үг сурах,

хэлний шинэ ойлголтыг тогтооход нь туслахын тулд байж болно.

Энэ хүрээнд бичих дасгал хийснээр суралцагч өөрийнхөө ахицад дүгнэлт хийхээс гадна багшаас санал бодлыг нь авах эргэх холбоо үүсдэг. Бичих дасгал нь ихэнхдээ өгүүлбэрийн түвшинд байдаг. Энэ нь хэл сурахад ач холбогдолтой боловч, бичих ур чадварыг бүрэн эзэмших нь алдаагүй, өгүүлбэр зөв бичихээс ч илүү хэрэгтэй. Бидний хувьд оюутанд санаагаа бүрэн илэрхийлэх, мэдээллийг холбож дэлгэрүүлэх, өөрийнхөө санааг тодорхой бүлэг хүмүүст зориулж илэрхийлэх чадвар эзэмшүүлэхийг илүүд үздэг. Энэ чадварыг төлөвшүүлснээр жагсаалтын гуравдугаар зүйл буюу бүхэл өгүүлбэр бичих, бүтэн эх бичих чадварыг эзэмшүүлнэ.

Бүхэл эх бичих дасгал ажил хийх нь амьдрал дээр нийгэм, боловсрол, ажил мэргэжлийнхээ хүрээнд англи хэлийг ашиглах чадвар бүхий оюутнуудыг бэлтгэж хэл сурахын эцсийн зорилгыг нь биелүүлнэ. Манай зарим оюутан англи хэлийг хэзээ, хэрхэн, юунд хэрэглэх шаардлагатай болохоо мэднэ. Харин зарим нь ирээдүйд англи хэлийг хэрхэн ашиглах талаар нарийн тодорхой ойлголтгүй байгаа нь ажиглагддаг. Багшийн хувьд бидний үүрэг нь шавь нартаа гадаад хэлээр харилцах чадварыг олгох явдал юм. Англи хэлийг хоёр дахь хэлээ болгон судалж байгаа олон оюутан хичээл болон шалгалтын үеэр эх бичиж чаддаг болдог нь тэдний англи хэлний чадвар ажиж байгааг харуулж байгаа хэрэг юм. Зарим оюутны хувьд англи хэлийг, бичгийн англи хэлийг амьдралдаа ашиглах хэрэгцээ тэр бүр байхгүй гэж үздэг боловч гадаад хэлний чадвараа сайжруулахын хамт зохиол, эсээ, тэр ч атугай бүр шүлэг бичих дуртай байдаг. Хичээлийн үеэр эх, зохион бичлэг бичих ажил хийснээр оюутнууд олон янзын сэдлээр бичгийн англи хэл сурах эрмэлзэлтэй болж байна.

Танхимд хийлгэх бичих дадлын ажил нь оюутныг гадаад хэлээр нэгдмэл, хам сэдэвтэй холбогдсон, санаагаа зөв илэрхийлсэн бүхэл эх бичих чадвартай болгох эцсийн зорилгыг тусгаж байх ёстой.

## 2. Бичих эв дүй

Бичих чадварыг сайжруулах нэг арга бол бичсэн эхэд анализ хийх арга юм. Энэ аргаар оюутан эх бичихийн тулд ямар ур чадвар эзэмшсэн байх хэрэгтэй вэ гэдгийг мэдэх боломжтой. Үүнд:

- Дүрмийн хувьд алдаагүй байх
- Үгийн баялагтай
- Тэмдэг тэмдэглэгээг зөв ашиглах
- Бичлэгийн хэл найруулга нь зөв /захидал бичих найруулга гэх мэт/
- Үг үсгийн алдаагүй байх
- Өгүүлбэрийн бүтцээ нэг хэвийн давтахгүй байх
- Олон өгүүлбэр ашиглан санаа, мэдээллийг холбож нэгдмэл санаа илэрхийлэх
- Агуулгыг тод, ойлгомжтой байдлаар боловсруулж бэлдэх

## 2. Харилцах үйл явц

Өөртөө зориулж санамж бичих, дэлгүүрээс авах зүйлийн жагсаалт гаргах, өдрийн тэмдэглэл хөглөх гэх зэргийг эс тооцвол бичих үйл явц нь харилцаа холбооны нэг төрөл юм. Бодит амьдрал дээр бид найз нөхөд, хамаатан садан, ажлын газрын хүн, компани, олон нийтийн байгууллага гээд хэн нэгэн хүнд зориулж бичдэг. Багш оюутнуудад хотыг дүрслэн бичих даалгавар өгсөн гэж үзье. Оюутан хэнд зориулж, ямар зорилгоор бичиж байгаагаа мэдэх хэрэгтэй болно. Жуулчинд зориулж гарын авлага бичих үү, найздаа зориулж захидал бичих үү гэдгээ мэдэх шаардлагатай. Тохиолдол бүрээс хамааран ямар дүрслэх үг хэрэглэх, санаагаа хэрхэн дугаарлах, энгийн, эсвэл албаны хэлээр бичих нь шалтгаална.

Өөрөөр хэлбэл, эхийн агуулга, бичлэгийн хэлбэр нь уншигчаас хамааралтай. Багшийн нэг чухал үүрэг нь оюутанд эх бичихэд жинхэнэ, эсвэл төсөөллийн уншигч бий болгох явдал юм.

## 3. Бичих үйл явц

Бичвэрээ амжилттай бичихийн тулд зохиогч буюу оюутан хэд хэдэн шат дарааллаар ажиллах нь илүү үр дүнтэй хэмээн үзэж байна.



Тэд эхлээд оюун ухаандаа ерөнхий төлөвлөгөө гаргаж, энэ нь бичих үйл явцад нөлөөлж, шинэ санаа өөрчлөлтийг бий болгоно. Мөн хэнд зориулж зохиомж бичиж байгаагаа тооцоолон, эхийн хэсгүүдийг ноороглож, ерөнхий бүтэц болон санаагаа зөв оновчтой илэрхийлэхэд анхаарлаа хандуулна. Дараа нь бичсэн зүйлээ дахин сайтар нягтлан уншиж, бичлэгээ сайжруулах, зөв бичгийн дүрэм, үгийн сонголт, тэмдэг тэмдэглэгээ гэх зэрэг нарийн зүйлийг анхааран засна. Өөрөөр хэлбэл, сайн зохиогч хэнд зориулж буй, бичсэн зүйлийг нь хэн уншихыг сайтар мэдэж байх ёстойгоос гадна эдгээрээс үндэслэн тодорхой чиглэл зорилготой бичих учиртай..

#### 4. Сайжруулах үйл явц

Санаагаа цуглуулж нэгтгэх, төлөвлөгөө гаргах, ноороглоход туслах нь багшийн үүргийн нэгээхэн хэсэг юм. Бидний өөр нэгэн чухал үүрэг нь оюутнуудын бичсэн бичвэрт үндэслэл бүхий тодорхой шүүмж өгөх замаар бичсэн зүйлээ сайжруулахад нь туслах явдал юм. Энэ нь хэд хэдэн шалтгаантай:

а. Зохиомж бичих нь оюуны маш их хөдөлмөр шаарддаг ба багш хийсэн ажилд нь хариу үйлдэл үзүүлэхгүй байх нь оюутныг мохож шантрахад хүргэдэг.

б. Оюутнууд бичихдээ ярихаасаа илүү өөрийгөө хянадаг учир тэдний хэлний чадварыг дүгнэх болон дутагдалтай талыг олоход үр дүнтэй байдаг.

в. Бичих нь яриа биш учраас хэзээ ч хамаагүй эргэж харж, засч залруулж болдог. Иймд бичгээр дамжуулан багш оюутнууддаа олон зүйл сургаж болно.

г. Багш шүүмж өгснөөр оюутан өөрийн гаргасан алдаанд дүн шинжилгээ хийж, улмаар бичих арга барилаа сайжруулна, өөрөөр хэлбэл алдаан дээрээ суралцах боломжийг олгоно. Дашрамд тэмдэглэхэд, өөрийн алдааг ухамсарлаж, бусдын хэрхэн зассаныг ойлгон хүлээн авах чадвар эзэмших нь сайн бичдэг болохын үндэс суурь хэмээн үзэж байна. Бусдаар засуулсан алдаагаа гүнзгий ухамсарлахгүй, эсвэл чухам яагаад ингэж зассаныг ухаж ойлгохгүй бол тэр хүн

найруулгагүй муу бичдэг хэвээрээ байсаар л байх болно.

#### 5. Бичихэд цаг гаргах

Сайн зохиомж бичдэг болохын тулд их унших хэрэгтэй гэсэн ойлголт байдаг. Энэ нь ч учиртай. Төрөл бүрийн эхийн бүтэцтэй танилцаж байж сайн бичих гэж юү гэсэн үгийг ойлгоно. Бид унших нь чухал боловч, үүний зэрэгцээ сайн бичиж сурахын тулд маш их бичих хэрэгтэй гэж бодож байна. Энэ бол тааруухан бичдэг оюутнуудад бүр их хамааралтай. Тэд өөрсдийнхөө муу бичдэгээ мэдэрдэгээс бичих хүсэл алга болж улам бүр доройтдог, тиймээс тэдний бичих чадвар тааруу хэвээрээ үлддэг.

Олон багш бичих даалгаварыг гэрийн даалгавар болгож өгдөг. Танхимд хичээллэх цаг бага учраас багш нар энэ цагийг ярих болон сонсох чадварт зориулахыг илүүд үзэж, бичих даалгаврыг хичээлийн бусад цагаар хийхээр өгдөг.

Гэвч, бичих дасгал даалгаврыг багшийн зааварчилгаан дор анги танхимд хийж гүйцэтгэх нь хавьгүй илүү үр дүнтэй болохыг практик нотолж байна. Бичихдээ тааруу оюутан ангидаа сайн бичиж байвал дараа нь гэртээ илүү их дадал хийж, улам бүр сайжирч байна.

#### 6. Хамтарч бичих нь

Ангидаа бичих дасгал хийх нь оюутнуудад хамтарч ажиллах боломж олгодог бас нэгэн сайн талтай. Багшийн эцсийн зорилго нь биеэ даан бичих чадвартай оюутан бэлтгэх боловч, хамтарч ажилласнаар ихийг сурах боломжтой.

Багаар хамтарч бичих дасгал хийснээр бичих шат болгонд багийн гишүүд хамтарч ажиллана.

- Багаараа хамтран санаагаа нэгтгэх боловсруулснаар хамгийн сайныг нь шилж сонгох боломжтой. Агуулгаа зөв сонгох нь сайн зохиомж бичихэд чухал нөлөөтэй.
- Багийн гишүүд хамтарч бичих дарааллаа сонгоно
- Эхийн анхны нооргоо бичиж байхдаа багийн нэг гишүүн нь “нарийн бичгийн

дарга"-ын үүрэг гүйцэтгэж, бусад нь өгүүлбэрийн бүтэц, үгийн сонголт, санаагаа холбох арга дээр санал бодлоо илэрхийлж, бичих явцдаа засвар хийж болдог.

Багаар хамтарч зохион бичсэнээр сурагчид бие биеэсээ суралцаж, тааруу сурагч сайнаасаа сурах боломжтой болдог. Багш баг хооронд явж туслалцаа үзүүлэх боломжтой.

#### 7. Бичихдээ туслалцаа авах

Оюутнуудад англи хэл дээр ямар нэгэн эх бичих үед бичсэн өгүүлбэрийнхээ бүтэц, үг хэллэгт сэтгэл дундуур байх үе олон байдаг. Оюутнууд утга санаагаа сайн гаргахад илүү анхаарал хандуулж байгаа нь ажиглагддаг. Заримдаа бодсон зүйлээ үгээр илэрхийлж чадахгүй байвал хоосон зай орхин цаасныхаа буланд төстэй утгатай үг, эсвэл монголоороо бичиж орхих нь элбэг тохиолдоно. Дараа нь бичсэн зүйлээ эргэн харж, нарийн зүйлд анхаарлаа хандуулж, шаардлагатай хэсгүүдийг сайжруулж бичдэг. Бид оюутнуудаа зохиолч хүн шиг бичдэг болгохын тулд толь бичиг хэрхэн ашиглахыг заах хэрэгтэй гэж үзэж байна. Тийм ч учраас сүүлийн үед оюутнуудыг өөрийн гэсэн ашиглах материал буюу өөрийн толь бичигтэй болгож, үгийн санг нь баяжуулахад түлхүү анхаарах болсон билээ.

#### 8. Ангиас гадуур бичих дасгал хийх

Өмнө нь оюутнуудын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, бичих чадварыг сайжруулахын тулд бичих дасгалыг гэрт биш, ангид хийлгэх хэрэгтэй гэсэн санаа гаргасан билээ. Гэхдээ хичээлээс гадуур, багшаар дүгнүүлэхгүйгээр бичих чадвараа дээшлүүлэх боломжийг тэдэнд мөн олгож байх нь чухал. Тиймээс хичээлээс гадуур, цагт баригдахгүйгээр, урт, богино янз бүрийн хэмжээний эх бичих нь ач холбогдолтой юм.

#### 9. Багш нар үлгэр дууриалал болох нь

Багш нар өөрсдөө бичих дур сонирхолтой төдийгүй сайн бичдэг байвал оюутнууд мөн адил бичих дуртай болж, тэднээсээ урам зориг авах байх гэж бодож байна. Оюутнууддаа зориулж захиа бичих, өдрийн

тэмдэглэл солилцох гэх мэт дасгалуудаар өөрийн бичих чадварыг харуулж, нэг ёсны туршлага солилцох хэрэгтэй.

Багш өөрийн бичих арга барил, ангид ашигладаг дадалга эдгээрийг бий болоход нөлөөлсөн ойлголтын талаар эргэцүүлэн бодоод, дараах асуултыг ашиглан өөрийгөө дүгнэх нь хичээл амжилттай үр дүнтэй болоход нөлөөлж болох юм. Үүнд:

1. Багш Та яагаад оюутнууддаа англиар бичих дасгал өгдөг вэ?

2. Шалгалтад ямар төрлийн бичгийн чадварыг оруулдаг вэ? Таны шалгалт оюутнуудын ирээдүйд ашиглах англи хэлний бичгийн чадварыг оновчтой сайн дүгнэж чаддаг уу?

3. Оюутнууд ангид ямар төрлийн бичих дасгал хийдэг вэ? Өгүүлбэр зохиох, бичих, бүтэн эх бичих гэх зэрэгт аль хэр их цаг зарцуулдаг вэ?

4. Багш та өөрөө хоёр дахь хэл дээр бичих чадвараа хэрхэн сайжруулсан, ямар бэрхшээл тулгарч байсан талаар бодож үзсэн үү?

5. Бичих чадвар сул байгаа нь хэлний ерөнхий түвшин сул байгаа болон бусад хүчин зүйлээс хэр хамааралтай гэж боддог вэ?

6. Оюутнууд ангидаа багшийн тусламжтайгаар бичих ажил хэр их хийдэг вэ?

7. Оюутнууд хамтарч бичиж, бие биенийхээ хийсэн ажилд дүгнэлт хийдэг үү?

### ДҮГНЭЛТ

Ангид бичих дадлын хичээл дээр хийсэн ажил нь оюутнуудыг англи хэл дээр нэгдмэл, хам сэдэвтэй холбогдсон, санаагаа зөв илэрхийлсэн бүхэл эх бичих чадвартай болгох эцсийн зорилгыг тусгаж байх ёстой.

Оюутнуудад янз бүрийн хэлбэр, үүрэг бүхий бичвэр бичих олон төрлийн чадвар хөгжүүлэх боломжийг багш олгодог байх хэрэгтэй.

Багш оюутнуудын бичвэрийг унших уншигчдыг зохиомлоор өөрчилж, өөр өөр уншигчид хандаж бичих дасгал өгөх хэрэгтэй. Бичсэн эх болгон ямар нэгэн учир шалтгаантай байх нь зүйтэй. Оюутнууд



хам сэдвээ ойлгосноор оновчтой зөв бичих чадвар нь нэмэгдэнэ.

Ангидаа унаган хэлтэй хүний бичих үйл явц арга барилыг дууриасан дасгал ажил хийлгэх хэрэгтэй. Оюутнуудыг төлөвлөх, системчлэх, бичих, засварлах үйл явцаар эх бичдэг арга сурахад туслах нь илүү үр өгөөжтэй байна.

Оюутнуудын алдааг засахад хэрэглэдэг уламжлалт аргыг өөрчилж, бичсэн зүйлээ засахад өөрсдөө идэвхитэй оролцдог болгож, зөвхөн дүгнэх, эсвэл алдаа хайхад биш, сайжруулахад анхаардаг болгох хэрэгтэй.

Суралцагчдад ангид бичих дадлын цаг хэрэгтэй. Багшийн үүрэг бол тэдний бичих дадал чадварыг улам чамбайруулахад чиглэсэн, шинжлэх ухааны үндэстэй эд дасгал, даалгавар боловсруулах явдал юм.

Ангид оюутнууд хамтран бичсэнээр санал бодлоо хуваалцаж, бичих үйл явц үр дүнтэй болно.

Ангиас гадуур бичих дасгал даалгавар хийлгэх нь оюутны бичих ур чадварыг сайжруулахаас гадна өөртөө итгэх итгэлийг бий болгодог байна.

Scrivener, J. (2005). *Learning Teaching* (2<sup>nd</sup> Edition) Macmillan Books for teachers

Yule, G. (2006). *The Study of Language* (3<sup>rd</sup> Edition). Cambridge: Cambridge University Press.

<http://eslcafe.com>

<http://www.englishforums.com>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Brown, H.D. (2000). *Principles of Language Learning and Teaching* (4<sup>th</sup> Edition). New York: Pearson Education.

Ellis, R. (2001). *Form-Focused Instruction and Second Language Learning*.

Ellis, R. (1997). *Second Language Acquisition*. Oxford: Oxford University Press.

Hedge, T. (2005). *Writing* (2<sup>nd</sup> Edition) Oxford University Press

Nunan, D. (1999). *Second Language Teaching and Learning* Heinle&Heinle Publishing.

Larsen-Freeman, D. (2000). *Techniques and Principles in Language Teaching* (2<sup>nd</sup> Edition). Oxford: Oxford University Press.

Richards, J. C. & Rodgers, T. S. (1986). *Approaches and Methods in Language Teaching*. Cambridge: Cambridge University Press.